

Монгол орны Алтай ба говийн бүсийн хадны зураг дахь амьтдын дүрслэлийн ялгаа ба онцлог

Пэрэнлэйлхүндэвийн Гантуяа 

Мэдээллийн технологи, электроникийн сургууль, Монгол Улсын их сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ gantuya@seas.num.edu.mn

Батсуурийн Сувдаа 

Мэдээллийн технологи, электроникийн сургууль, Монгол Улсын их сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Рэнцэндоржийн Элчинбат

Мэдээллийн технологи, электроникийн сургууль, Монгол Улсын их сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Монгол орны хадны зураг нь Евразийн нүүдэлчдийн соёл, байгаль орчин, аж ахуйн хэв маягийн харилцан шүтэлцээг илтгэх археологийн болон дүрслэх урлагийн чухал өв юм. Энэхүү судалгаанд Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбороос Цагаан салаа-Бага Ойгор, Шивээт хайрхан, Арал толгой, говийн бүсээс Дэл уул, Хавцгайт зэрэг төлөөлөх дурсгалуудыг сонгон авч, буга, аргал, янгирын дүрслэлийг хэлбэр зүйн, дүрс зүйн тайлбарын болон зохиомжийн шалгуураар харьцуулан шинжиллээ. Судалгааны үр дүнгээс харахад Алтайн бүсийн хадны зурагт амьтдын биеийн хэлбэрийг уртасгах, эвэр болон биеийн хэсгийг онцлон томруулах зэргээр загварчилсан дүрслэл давамгайл бол говийн бүсэд амьтдыг ан агнуурын дүр зураг, хөдөлгөөнтэй зохиомжийн хүрээнд илэрхийлэх хандлага илүү тод байна. Гэсэн хэдий ч говийн бүсийн аргал, янгирын дүрслэлийг зөвхөн аж ахуйн хэрэглээний хүрээнд тайлбарлах нь хангалтгүй бөгөөд тэдгээрт зан үйл, бэлгэдлийн давхар утга агуулагдсан байж болохыг харгалзан үзэх шаардлагатай. Иймээс энэхүү харьцуулсан судалгаа нь монголын хадны зургийн бүс нутгийн хэлэмжийг тодруулахын зэрэгцээ нүүдэлчдийн гоо зүйн сэтгэлгээ, байгаль орчны танин мэдэхүй, соёлын бэлгэдлийн ялгааг цаашид нарийвчлан судлах онол, арга зүйн ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: хадны зураг, Монгол Алтай, говь, амьтны дүрслэл, буга, аргал, янгир, хэлбэр зүй, дүрс зүйн тайлбар, загварчилсан, хөдөлгөөнт зохиомж

Differences and Characteristics of Animal Depictions in the Rock Art of the Altai and Gobi Regions of Mongolia

Gantuya Perenleikhundev 

School of Information Technology and Electronics, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

 gantuya@seas.num.edu.mn

Suvdaa Batsuuri 

School of Information Technology and Electronics, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

Elchinbat Rentsendorj

School of Information Technology and Electronics, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: The rock art of Mongolia is an important archaeological and visual art heritage that reflects the interrelationship between the culture, environment, and economic practices of Eurasian nomadic societies. In this study, representative rock art sites were selected from the Mongolian Altai, including Tsagaan Salaa–Baga Oigor, Shiveet Khairkhan, and Aral Tolgoi, as well as from the Gobi region, including Del Uul and Khavtsgait. The depictions of deer, argali, and ibex were comparatively analyzed according to morphological, iconographic, and compositional criteria.

The results of the study show that in the rock art of the Altai region, stylized representations predominate, characterized by elongated animal body forms and the emphasized enlargement of horns and other body parts. In contrast, the rock art of the Gobi region more clearly tends to depict animals within hunting scenes and dynamic compositions. However, the depictions of argali and ibex in the Gobi region cannot be sufficiently interpreted solely within the framework of economic or utilitarian practices; it is also necessary to consider that they may contain ritual and symbolic layers of meaning.

Therefore, this comparative study is significant not only for clarifying the regional visual language of Mongolian rock art, but also for providing a theoretical and methodological basis for further detailed research into the aesthetic thinking, environmental perception, and cultural symbolism of nomadic societies.

Keywords: *rock art, Mongolian Altai, Gobi, animal depiction, deer, argali, ibex, morphology, iconographic interpretation, stylized representation, dynamic composition*

Оршил

Хадны зураг нь хүн төрөлхтний хамгийн эртний дүрслэх урлагийн хэлбэрүүдийн нэг бөгөөд ан агнуур, зан үйл, байгаль орчны тухай ойлголтыг илэрхийлсэн соёлын баримт болдог (Whitley 2005). Монгол орны хадны зургийн дурсгалууд газар зүйн хувьд өндөр уул, хээр тал, говийн хуурай бүс зэрэг олон янзын байгалийн орчинд тархсан. Ийм ялгаатай орчинд амьтдын төрөл зүйл, ан агнуурын арга, мал аж

ахуйн зохион байгуулалт, зан үйлийн төсөөлөл өөр өөрөөр бүрэлдсэн тул хадны зураг дахь амьтдын дүрслэлийн хэлбэр, хөдөлгөөн, зохиомжид бүс нутгийн ялгаа илрэх боломжтой.

Монголын хадны зургийн судалгаанд А.П.Окладников, В.В.Волков, Д.Цэвээндорж нарын Монгол Алтай болон Төв Азийн хадны зураг, буган чулуун хөшөө, бүс нутгийн олдворын тойм судалгаанууд суурь ач холбогдолтой (Okladnikov 1981; Volkov 1981; Tseveendorj et al. 1999). Тэдгээр судалгаанд хадны зургийг зөвхөн зураглалын баримт бус, эртний нүүдэлчдийн зан үйл, шүтлэг, байгальтай харилцах ойлголтын илэрхийлэл гэж тайлбарласан нь энэ өгүүллийн онолын үндэслэлтэй шууд холбогдоно.

Амьтны дүрслэлийг энэ өгүүлэлд зөвхөн биологийн төрөл зүйлээр бус, нүүдэлчдийн аж ахуй, ан агнуурын дадал, сүрэг малын зохион байгуулалт, бэлгэдэл, гоо зүйн сэтгэлгээтэй холбон авч үзэв. Ийм байр суурь нь хадны зураг дахь буга, аргал, янгирын дүрслэлийг тухайн бүсийн байгаль орчин ба соёлын харилцааны нийлмэл баримт болгон унших боломж олгоно.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Алтай болон Говийн бүсийн хадны зурагт дүрслэгдсэн буга, аргал, янгир зэрэг амьтдын дүрслэлийн хэлбэр зүй, дүрс зүйн утга, зохиомжийн ялгаа ба онцлогийг харьцуулан тайлбарлахад оршино. Үүний хүрээнд дараах судалгааны асуултыг дэвшүүлэв.

1. Алтай ба Говийн бүсийн төлөөлөх дурсгалуудад ямар амьтдын дүрслэл зонхилж байна вэ?
2. Буга, аргал, янгирын биеийн хэлбэр, эвэр, хөдөлгөөний илэрхийлэл, зохиомжийн бүтэц бүс нутгаар хэрхэн ялгаатай байна вэ?
3. Эдгээр ялгааг тухайн бүсийн байгаль орчин, ан агнуур, нүүдэлчдийн аж ахуй, зан үйлийн бэлгэдэлтэй хэрхэн холбон тайлбарлаж болох вэ?

Судалгааны эх сурвалж, арга зүй

Судалгааны объект: Монголын хадны зургийн дурсгалууд газар зүйн хувьд олон бүсэд тархсан боловч энэ өгүүлэлд өндөр уулын орчинтой Монгол Алтай болон хуурай говийн орчны төлөөлөх дурсгалуудыг сонгон харьцуулсан. Сонголтын үндэслэл нь хоёр бүс хоёулаа амьтны дүрслэлээр баялаг боловч байгаль орчин, амьтны аймаг, аж ахуйн хэлбэр, дүрслэлийн зохиомжийн хувьд ялгаатай байгаад оршино.

Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дахь Арал толгой, Шивээт хайрхан, мөн Улаанхус сумын Цагаан салаа-Бага Ойгор зэрэг дурсгалуудаас бүрдэнэ. Энэ бүсийн дурсгалууд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн бөгөөд буга, аргал, янгир зэрэг уулын амьтдын дүрслэл болон хэв маягжуулсан хэлбэрийн өндөр хөгжлөөрөө онцлог (Jacobson-Tepfer 2012; Amarsanaa n.d.; Tseveendorj et al. 1999).

Говийн бүсийг төлөөлүүлэн Дэл уул, Хавцгайт, Тэвш уул, Жавхлант хайрхан зэрэг дурсгалын мэдээллийг авч үзэв. Эдгээр дурсгалд янгирын дүрслэл, ан агнуурын дүр зураг, хүн-амьтны харилцаа, хөдөлгөөнт зохиомж түгээмэл ажиглагддаг (Batbold 2014; Batbold and Gantulga 2016). Харин аргал говийн судалгааны хэрэглэгдэхүүнд бүртгэгдсэн боловч энэ өгүүллийн харьцуулсан

индексээр янгиртай харьцуулахад бага хувьтай байгаа тул дүгнэлтэд энэ ялгааг тусгайлан харгалзав.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хадны зургийн бүс, байгаль орчны онцлог, дурсгалын нэршил

Бүс	Байгаль орчин	Сонгосон дурсгал, байршил
Алтай	Өндөр уул, хөндий, хад асга бүхий орчин	Баян-Өлгий: Цагаан салаа-Бага Ойгор, Шивээт хайрхан, Арал толгой
Говь	Хуурай болон хагас хуурай тал, хадархаг уулс	Өмнөговь, Дундговь, Дорноговь орчим: Дэл уул, Хавцгайт, Тэвш уул, Жавхлант хайрхан



Зураг 1. а. Хавцгайтын хадны зураг



б. Дэл уулын хадны зураг

Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор нь Арал толгой, Шивээт хайрхан, Цагаан салаа-Бага Ойгор зэрэг дурсгалт газруудаас бүрдэх бөгөөд нийтдээ 100,000 гаруй хадны зураг, дүрслэл бүртгэгдсэн Төв Азийн томоохон хадны зургийн төвүүдийн нэг юм (Jacobson-Tepfer 2012; Amarsanaa). Говийн бүсийн хувьд Н.Батболдын судалгаанд 52 байршлын 5000 гаруй дүрслэлийг авч үзсэн нь энэ өгүүллийн харьцуулалтын нэг үндсэн эх сурвалж болов (Batbold 2014).

Судалгааны арга

Судалгаанд дараах аргууд болон харьцуулалтын шалгуур үзүүлэлтийг ашиглав. Харьцуулалтыг дараах дарааллаар гүйцэтгэсэн. Нэгдүгээрт, эх сурвалжид тодорхой дурдагдсан дурсгал, байршлыг бүс нутгаар ангилсан. Хоёрдугаарт, амьтны төрлийг буга, аргал, янгир, адуу, үхэр/сарлаг, тэмээ, гахай, бусад гэсэн бүлгээр нэгтгэсэн. Гуравдугаарт, биеийн хэлбэр, эвэр, хөл, толгой, хүзүүний байрлал зэрэг хэлбэр зүйн шинжийг тэмдэглэсэн. Дөрөвдүгээрт, ганц дүр, сүрэг, хүн, амьтны харилцаа, ан агнуурын дүр зураг, зан үйлийн боломжит нөхцөл гэсэн зохиомжийн төрлөөр ангилсан. Тавдугаарт, хоёр бүсийн өгөгдөл нь хэмжээний хувьд тэнцүү биш тул тоон дүнг шууд түүврийн хувь бус, эх сурвалжийн бүртгэлд тулгуурласан нормчилсон харьцуулалтын индекс болгон ашиглав.

Иймээс Хүснэгт 2-т үзүүлсэн тоон мэдээлэл нь шинэ бүрэн тооллого бус, өмнөх судалгааны бүртгэлээс нэгтгэн авсан харьцуулалтын үзүүлэлт юм. Түүврийн хэмжээ, бүртгэлийн арга зөрүүтэй байгаа нь энэ судалгааны хязгаарлалтад тооцогдох бөгөөд цаашид хоёр бүсээс ижил шалгуураар сонгосон зурагт нэг бүрчлэн тооллого хийж статистикийн нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай.

1. Хэлбэр зүйн задлан шинжилгээ: амьтдын биеийн хэлбэр, пропорц, эвэр, хөл, хөдөлгөөний илэрхийллийг судлах
2. Дүрс зүйн тайлбарын арга: амьтдын бэлгэдлийн утга, зан үйл, соёлын холбоог тайлбарлах
3. Зохиомжийн задлан шинжилгээ: дүрсүүдийн харилцан байрлал, чиглэл, бүлэглэл, хүүрнэлт бүтэц, хүн амьтны харилцааг судлах
4. Харьцуулсан арга: дээрх шалгуур үзүүлэлтээр Алтай ба Говийн бүсийн ижил болон ялгаатай шинжийг тодорхойлох

1. Хэлбэр зүйн задлан шинжилгээ: Хэлбэр зүйн задлан шинжилгээ нь хадны зурагт дүрслэгдсэн амьтдын биеийн ерөнхий хэлбэр, пропорц, эвэр, хөл, толгой-хүзүүний байрлал, хөдөлгөөний илэрхийллийг судлах арга юм. Энэ судалгаанд буга, аргал, янгирын дүрслэлийг дараах үндсэн үзүүлэлтээр шинжилсэн.

- их биеийн урт ба өндөр
- хөлний урт
- эвэрний хэлбэр ба хэмжээ
- толгой-хүзүүний байрлал
- нурууны хэлбэр

Эдгээр үзүүлэлт нь амьтны дүрслэл бодит дүрслэлд ойр байна уу, эсвэл уртасгасан бие, онцолсон эвэр, шугаман хураангуйлал зэрэг хэв шинжтэй байна уу гэдгийг тодорхойлох боломж олгодог. Жишээлбэл, Алтайн бүсийн зарим бугын дүрслэлд уртасгасан бие, том салаалсан эвэр бүхий хэв маяг бүхий хэлбэр илэрдэг бол говийн бүсийн зарим дүрслэлд биеийн пропорцыг энгийн шугам, хөдөлгөөнөөр илэрхийлсэн байдаг.

2. Дүрс-зүйн тайлбарын арга: Дүрс-зүйн тайлбарын арга нь дүрслэлийн утга, бэлгэдэл, зан үйлийн боломжит холбоог тайлбарлахад чиглэнэ. Энэ судалгаанд буга, аргал, янгирын дүрслэлийг дараах нөхцөлд авч үзсэн.

- дан бугын дүр
- сүргээр дүрслэгдсэн буга
- ан агнуурын дүр зураг дахь амьтны дүр
- зан үйлтэй холбоотой дүрслэл

Дүрс-зүйн тайлбарын арга нь амьтны дүр тухайн соёлын үнэт зүйл, шүтлэг, зан үйл, аж ахуйн хэрэглээнд ямар байр суурьтай байсныг тодорхойлоход тусалдаг (Tacon and Chippindale 1998).

3. Зохиомжийн задлан шинжилгээ: Зохиомжийн задлан шинжилгээ нь хадны зурагт дүрслэгдсэн дүрсүүдийн харилцан байрлал, чиглэл, бүлэглэл, үйл явдлын холбоо, хүүрнэлт бүтцийг судална. Судалгаанд дараах зохиомжийн төрлүүд ажиглагдсан.

- ганц амьтны дүр
- сүрэг
- хүн ба амьтны харилцаа
- ан агнуурын дүр зураг

Говийн бүсийн хадны зурагт ан агнуурын дүр зураг, хүн-амьтны харилцаа, хөдөлгөөнт зохиомж тод илрэх бол Алтайн бүсэд ганц амьтны дүр болон сүргийн зохиомж, хэв маягжуулсан бэлгэдлийн хэлбэр илүү ажиглагдана.

4. Харьцуулсан арга: Энэхүү судалгаанд бүс нутгийн ялгааг тодорхойлохын тулд харьцуулсан аргыг ашиглав. Алтай, Говийн бүсийн хадны зурагт буга, аргал, янгирын хэлбэр зүйн шинж, дүрс-зүйн утга, зохиомжийн бүтэц, хөдөлгөөний илэрхийллийг ижил шалгуураар харьцуулсан.

Хэрэгжүүлэлт, үр дүн

Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (Цагаан салаа-Бага Ойгор, Шивээт хайрхан, Арал толгой) нь олон мянган дүрслэлтэй бөгөөд амьтдын дүрслэл, ялангуяа янгир, аргал, буга зэрэг уулын амьтны хэлбэр давамгайлдаг (Jacobson-Tepfer 2012; Amarsanaa n.d.; Tseveendorj et al. 1999). Эдгээр дүрслэлд уртасгасан их бие, онцолсон эвэр, сүрэг болон ганц дүрийн зохиомж зэрэг шинж илэрнэ.

Говийн бүсийн хувьд Н.Батболдын “Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа” бүтээлд дурдагдсан 52 байршлын 5000 гаруй дүрслэлийн нэгтгэлийг шинжилгээний үндэслэл болгов (Batbold 2014). Говийн хэрэглэгдэхүүнд янгирын дүрслэл илүү давамгай байгаа боловч аргал харьцангуй цөөн бүртгэгдсэн нь “аргал, янгир хоёулаа элбэг” гэх ерөнхий дүгнэлтийг засаж, амьтан тус бүрээр ялган тайлбарлах шаардлагатайг харуулна.

Хүснэгт 2. Алтай, Говийн хадны зурагт дүрслэгдсэн амьтдын нормчилсон харьцуулалтын индекс

Амьтан	Алтай	Говь
	Нормчилсон индекс (%)	
Янгир	30.7	54.5
Аргал	21.9	3.0
Буга	17.5	7.1
Адуу	13.2	12.1
Үхэр / сарлаг	6.1	2.0
Бусад амьтан	8.8	18.2
Тэмээ	0.9	2.0
Гахай	0.9	1.0

Хүснэгт 2-т өмнөх эх сурвалжийн тоон мэдээллийг бүс тус бүрт 100 хувь болгон нормчилж харуулав. Үүнээс харахад янгирын дүрслэл Говьд 54.5%, Алтайд 30.7% буюу Говийн бүсэд илүү давамгай байна. Харин аргал Алтайд 21.9%, Говьд 3.0%; буга Алтайд 17.5%, Говьд 7.1% байгаа нь Алтайн бүсэд аргал, бугын дүрслэл харьцангуй өндөр байгааг илтгэнэ. Иймээс Говийн бүсийг “аргал, янгир элбэг” гэж ерөнхийлөхөөс илүү “янгир давамгай, аргал харьцангуй цөөн” гэж өгөгдөлд тулгуурлан тайлбарлах нь зохистой.

Хэлбэр зүйн задлан шинжилгээний үр дүнд буга, аргал, янгирын дүрслэлийг дараах таван үндсэн хэв маягт ангилж болно.

1. Бодит дүрслэлийн хэв маяг: Энэ хэв маягт бугын биеийн пропорц бодит амьтны хэлбэртэй ойролцоо байдаг. Ийм төрлийн дүрслэл Алтайн бүсийн эрт үеийн хадны зурагт ажиглагддаг (Jacobson-Tepfer 2012).

2. Бодит дүрслэлийн чимэглэсэн хэлбэр: Энэ хэв маягт бугын биеийн хэлбэр бодит хэвээр боловч эвэр, нуруу, биеийн гадаргуу дээр нэмэлт шугам, гоёлын элементүүд орсон байдаг.
3. Хэв маягжуулсан бугын дүрслэл: Энэ хэв маяг нь бугын биеийг уртасгах, эвэрийг хэт томруулах, зарим хэсгийг бэлгэдлийн шинжтэй онцлох хэлбэрээр илэрдэг. Энэ нь хүрэл зэвсгийн үеийн буган чулуун хөшөөний дүрслэлийн уламжлалтай холбоотой гэж үздэг (Francfort 2001; Volkov 1981; Jacobson-Tepfer 2012).
4. Тоймчилсон бугын дүрслэл: Энэ хэв маягт бугын биеийг энгийн шугаман болон хураангуй хэлбэрээр илэрхийлдэг. Энэ төрлийн дүрслэл говийн бүсийн хадны зурагт илүү ажиглагддаг (Batbold 2014).
5. Өгүүлэмжит буюу үйл явдалт бугын дүрслэл: Энэ нь бугын дүрслэл хүн, морь, ан агнуурын дүр зураг зэрэгтэй хамт орж, тодорхой үйл явдал буюу хүүрнэлт бүтцийг илэрхийлсэн байдлаар илэрдэг (Batbold 2014; Tacon and Chippindale 1998).

Хүснэгт 3. Амьтны дүрслэлд ашигласан шинжилгээний шалгуурын харьцуулалт

Амьтан	Бүс	Хэлбэр зүйн шинж	Дүрс-зүйн тайлбар	Хэв маяг	Хөдөлгөөний илэрхийлэл	Зохиомж
Буга	Алтай	уртасгасан бие, том салаалсан эвэр	бэлгэдлийн шинж, ганц дүр буюу сүрэг	хэв маягжуулсан	тогтуун	сүрэг, дан дүр
	Говь	шугаман бие, энгийн эвэр	ан агнуурын дүр зурагтай холбогдох	тоймчилсон	хөдөлгөөнт	ан агнуурын дүр зураг
Аргал	Алтай	том дугуй эвэр, тод биеийн хэлбэр	сүргийн болон бэлгэдлийн утга	хэв маягжуулсан	тогтуун	сүрэг
	Говь	хөнгөн шугаман хэлбэр, тоон хувьд цөөн	хөдөлгөөн, зан үйлийн боломжит утга	тоймчилсон	хөдөлгөөнт	цөөн жишээ, ан агнуурын орчин
Янгир	Алтай	том нумархай эвэр, уртасгасан бие	бие даасан дүр, сүрэг, бэлгэдэл	хэв маягжуулсан	тогтуун	сүрэг, дан дүр
	Говь	урт хөл, хөдөлгөөнийг онцолсон шугам	ан агнуурын дүр зураг, зан үйлийн боломжит утга	тоймчилсон	хөдөлгөөнт	ан агнуурын дүр зураг

Алтай болон Говийн бүсийн хадны зурагт ижил амьтад дүрслэгддэг боловч тэдгээрийн хэлбэр зүй, дүрс-зүйн утга, зохиомжийн шинж ялгаатай байна. Алтайн бүсэд амьтдыг хэв маягжуулсан, бэлгэдлийн шинжтэй дүрсэлсэн жишээ олон бол Говийн бүсэд ялангуяа янгирыг хөдөлгөөнтэй, ан агнуурын дүр зурагтай холбон дүрслэх хандлага тод ажиглагдана. Гэхдээ говийн аргал, янгирын дүрслэлийг зөвхөн аж ахуйн хэрэглээний утгаар хязгаарлахгүй, зан үйл, шүтлэгийн боломжит давхар утгыг харгалзах нь зүйтэй.



Хүснэгт 4-өөс харахад янгир болон бугын дүрслэл бүс нутгийн орчноос хамааран өөр өөр хэлбэр, зохиомж, хөдөлгөөний илэрхийлэлтэй байна. Энэхүү хүснэгт нь зураг бүрийг дахин тоочихоос илүүтэй, Алтайн хэв маягжуулсан хэлэмж ба Говийн хөдөлгөөнт, үйл явдалт зохиомжийн ялгааг нэгтгэн харуулах зорилготой.

Хэлэлцүүлэг

Алтай, Говийн бүсийн хадны зурагт дүрслэгдсэн буга, аргал, янгирын дүрслэлийг харьцуулан шинжлэхэд Монголын хадны зургийн уламжлалд бүс нутгийн орчноос шалтгаалсан хэлбэр, зохиомж, утгын ялгаа ажиглагдав. Алтайн бүсийн дүрслэлд уртасгасан бие, хэт томруулсан эвэр, сүрэг болон ганц дүрийн зохиомж давамгай байгаа нь Э.Якобсон-Тепферийн Алтайн хадны зургийн судалгаанд дурдсан хэв маягжуулсан амьтны хэлэмжтэй нийцэж байна (Jacobson-Tepfer 2012). Мөн буган чулуун хөшөөний дүрслэлтэй холбогдох томруулсан эвэр, нисэх мэт суналт бүхий хэлбэр нь В.В.Волковын буган чулуун хөшөөний уламжлалын судалгаатай харьцуулахад амьтны дүрийг зөвхөн байгалийн зураглал бус, бэлгэдэл, гоо зүйн хэв шинж болгож байсныг илтгэнэ (Volkov 1981).

Говийн бүсийн дүрслэлд янгирын эзлэх хувь өндөр бөгөөд хөдөлгөөн, хөөх, зугтах, хүн-амьтны харилцаа бүхий ан агнуурын дүр зураг илүү тод байна. Харин Хүснэгт 2-т аргал 3.0% буюу харьцангуй бага үзүүлэлттэй тул “говьд аргал, янгир элбэг” гэж ерөнхийлөх нь бодит өгөгдөлтэй зөрчилдөнө. Иймээс говийн бүсийн үндсэн онцлогийг “янгир давамгай, хөдөлгөөнт ан агнуурын дүр зураг илүү” гэж тодорхойлох нь илүү оновчтой. Энэ дүгнэлт нь Н.Батболдын говийн бүсийн хадны зургийн судалгаанд тэмдэглэсэн ан агнуур, хүн-амьтны харилцааны зохиомжтой нийцнэ (Batbold 2014).

Гэхдээ Алтайн дүрслэлийг зөвхөн “бэлгэдлийн”, Говийн дүрслэлийг зөвхөн “аж ахуйн” гэж шууд дүгнэх нь учир дутагдалтай. Говийн янгир, аргал нь ан агнуурын дүр зурагт оролцохын зэрэгцээ “тэнгэрийн амьтан”, уул усны эзэн, зан үйлийн төсөөлөлтэй холбоотой байж болох талтай. Иймээс говийн хөдөлгөөнт зохиомж нь ахуйн үйл явдлыг үзүүлэхийн зэрэгцээ зан үйлийн, шүтлэгийн давхар утга агуулсан байх боломжийг цаашид тусгайлан судлах шаардлагатай.

Ижил амьтан өөр өөр бүсэд өөр өөр хэлбэрээр дүрслэгдсэн нь нүүдэлчдийн дүрслэх уламжлалын уян хатан чанарыг харуулна. Алтайн хадны зурагт амьтны бие, эвэр, сүргийн зохиомжийг хэв маягжуулан бэлгэдлийн өндөр түвшинд илэрхийлэх хандлага илэрч байхад, Говьд хөдөлгөөн, үйл явдал, ан агнуурын орчныг илүү тодруулсан байна. Энэ ялгаа нь тухайн бүсийн амьтны аймаг, ландшафт, амьжиргааны хэлбэрээс гадна дүрслэх арга, хадны гадаргуу сонголт, цохиж сийлэх техник зэрэг хүчин зүйлтэй холбоотой байж болох юм.

Энэхүү судалгааны шинэлэг тал нь Алтай ба Говийн хадны зургийн амьтны дүрслэлийг нэг бүсийн доторх хэв шинжээр бус, хоёр өөр эко-бүсийн дүрслэлийн хэлэмжийн ялгаа болгон харьцуулсанд оршино. Өмнөх судалгаанууд тодорхой дурсгал, бүс нутгийн бүртгэл, дүрслэлийн тайлбар, он цагийн асуудлыг түлхүү авч үзсэн бол энэ өгүүлэлд хэлбэр зүй, дүрс-зүйн утга, зохиомжийн шалгуурыг нэгтгэн хэрэглэж, бүс хоорондын ялгааг тайлбарлахыг зорилоо.

Судалгааны хязгаарлалт нь хоёр бүсийн өгөгдлийн хэмжээ, бүртгэлийн арга, эх сурвалжийн нарийвчлал харилцан адилгүй байгаатай холбоотой. Алтайн бүсэд бүртгэгдсэн нийт дүрслэлийн хэмжээ говийн хэрэглэгдэхүүнээс үлэмж их тул Хүснэгт 2-ын үзүүлэлтийг бүрэн статистик түүвэр бус, нормчилсон харьцуулалтын индекс гэж ойлгоно. Цаашид хоёр бүсээс ижил тооны зураг, ижил төрлийн дурсгал, ижил он цагийн хүрээг сонгон, амьтны төрөл тус бүрийг нэг бүрчлэн тоолж, дүрслэлийн техник (цохиж сийлэх, зурах), хадны гадаргуу, давхар сийлбэр, зохиомжийн төвлөрөл зэргийг хамруулсан нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.

Дүгнэлт

Энэхүү судалгаанд Монгол Алтайн нурууны Цагаан салаа-Бага Ойгор, Шивээт хайрхан, Арал толгой болон Говийн бүсийн Дэл уул, Хавцгайт зэрэг дурсгалуудын хэрэглэгдэхүүнд тулгуурлан буга, аргал, янгирын дүрслэлийн хэлбэр зүй, дүрс-зүйн утга, зохиомжийн онцлогийг харьцуулан авч үзэв. Судалгааны үр дүнгээс харахад хоёр бүсэд ижил амьтад дүрслэгддэг боловч тэдгээрийн дүрслэх хэлэмж, хөдөлгөөний илэрхийлэл, зохиомжийн үүрэг тодорхой ялгаатай байна.

Алтайн бүсийн хадны зурагт амьтдыг уртасгасан бие, томруулсан эвэр, сүрэг болон ганц дүрийн зохиомж бүхий хэв маягжуулсан хэлбэрээр дүрсэлсэн нь бэлгэдлийн болон гоо зүйн шинжтэй байж болохыг харуулна. Харин Говийн бүсэд ялангуяа янгирын дүрслэл хөдөлгөөнт зохиомж, ан агнуурын дүр зураг, хүн-амьтны харилцаатай холбогдон илүү тод илэрч байна. Гэхдээ говийн аргал, янгирын дүрслэлийг зөвхөн ахуйн хэрэглээний хүрээнд тайлбарлах бус, зан үйл, шүтлэгийн боломжит утгыг хамтад нь авч үзэх шаардлагатай.

Ийнхүү Алтай ба Говийн бүсийн хадны зургийн дүрслэлийн ялгаа нь тухайн бүсийн байгаль орчин, амьтны аймаг, ан агнуурын соёл, нүүдэлчдийн аж ахуйн хэлбэр, бэлгэдлийн сэтгэлгээ зэрэг хүчин зүйлтэй холбоотой байна. Энэхүү харьцуулсан судалгаа нь Монголын хадны зургийн урлагийн уламжлал, нүүдэлчдийн гоо зүйн сэтгэлгээ, бүс нутгийн соёлын хэлэмжийг ойлгоход хувь нэмэр оруулах бөгөөд цаашид түүврийн тэнцвэр, дүрслэлийн техник, он цагийн ангиллыг нарийвчлан хамруулсан судалгаагаар үр дүнг баталгаажуулах шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

Гадаад хэлээр:

Francfort, H. 2001. "Rock art in Central Asia." *Antiquity* 75: 112–123.

Jacobson-Tepfer, E. 2017. "The Rock Art of Mongolia." *Archaeology Press (University of Oregon, Eugene)*: 5-13.

Tacon, P., & Chippindale, C. 1998. *The Archaeology of Rock Art*. Cambridge: Cambridge University Press.

Whitley, D. 2005. *Introduction to Rock Art Research*. New York: Left Coast Press.

Монгол хэлээр:

Амарсанаа, Г. 2025. “Хадны зураг дүрслэх урлагийн язгуур үндэс болох нь (Цагаан салаа-Бага Ойгорын дурсгалт газрын жишээгээр).” *Оюуны хэлхээ* Боть II.(29): 89-102.

Батболд, Н. 2014. *Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа*. Улаанбаатар.

Батболд, Н. Гантулга, Ж. нар. 2016. *Монголын хадны зураг*. Улаанбаатар.

Волков, В.В. 1981. *Оленные камни Монголии*. Улан-Батор: Издательство АН МНР.

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (Сэдэвчилсэн лавлах) 1999. Эрх. Дашням Л. Улаанбаатар: УХГ.

Окладников, А.П. 1981. *Петроглифы Чулутын-гола (Монголия)*. Новосибирск: Наука.

Цэвээндорж, Д., Кубарев, В.Д., Якобсон, Э. 1999. *Арал толгойн хадны зураг*. Улаанбаатар.

Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн, БШУЯ, Монголын үндэсний музей. 2022. *Хаданд сийлсэн эртний урлаг, Хадны зураг-Дэлхийн өв*. Улаанбаатар.